


БАТЛАВ:  
НИЙСЛЭЛИЙН ЗАМ, ТЭЭВРИЙН  
АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨСЛҮҮДИЙН  
УДИРДАГЧ



Б.ОТГОНСҮХ

АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

ЗӨВШӨӨРСӨН:  
НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ TYP ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ИНДРА

Дугаар: 3Д2020/016

Улаанбаатар хот

|    |   |   |
|----|---|---|
| 1  | Зураг төсөл боловсруулах үндэслэл         | -Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 сарын 25-ны өдрийн A/1359 дугаар захирамж<br>-Хот байгуулалт, Хөгжлийн газрын 2020 оны 01 сарын 20-ний өдрийн ГБМЗХ2020/01-012 дугаартай Авто зам, замын байгууламж төлөвлөх архитектур төлөвлөлтийн даалгавар   |
| 2  | Байршил                                   | УБ хот, Налайх дүүрэг, 1, 7 дугаар хороо, Цайз чиглэлийн авто замаас спорт цогцолбор хүртэлх авто зам, замын байгууламж   |
| 3  | Хөрөнгө оруулалтын эх үүсвэр              | Нийслэлийн төсвийн хөрөнгөөр  |
| 4  | Авто замын техникийн ангилал, замын зэрэг | Нутаг дэвсгэрийн зам  |
| 5  | Газрын бартаалаг, төвөгшил                | Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах  |
| 6  | Замын хучилтын хийц                       | Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ   |
| 7  | Зураг төсөл зохиох үе шат, хугацаа        | 1 үе шаттай 2020 он   |
| 8  | Зураг төслийн байгууллага                 | Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага  |
| 9  | Захиалагч байгууллага                     | Нийслэлийн Авто замын хөгжлийн газар  |
| 10 | Зураг төслийн иж бүрдэл                   | <ol style="list-style-type: none"> <li>Инженер геодезийн ажлын тайлан</li> <li>Инженер геологийн судалгааны ажлын тайлан</li> <li>Авто зам, замын байгууламжийн зураг төсөл</li> <li>Тайлбар бичиг (ажлын нэр, тоо хэмжээ, явган замын зураг төслийн бүрдэл, холбогдох захирамж, техникийн нөхцөл, магадлалын дүгнэлт гэх мэт)</li> <li>Техникийн шаардлага</li> <li>Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв</li> </ol> |

11. Онцгой нөхцөл:

- Авто замын зургийг Монгол улсад мөрдэж буй “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016, “Авто зам, гуурийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ” БД81-104-02, “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм” БНБД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” БД31.101.04, “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНБД 32-02-12, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009, “Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам, замын

байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам” болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөх буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх

- “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах
- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх. Геодезийн хяналтын инженерээр байр зүйн зураглалыг зураг төслийн төлөвлөлтийн шатанд хянуулж баталгаажуулах
- Налайх дүүргийн хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хороолол доторх шинээр болон өргөтгөл шинэчлэлт хийгдэж байгаа авто замын зураг төслийн трасстай уялдуулан зураг төслийг боловсруулах
- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох. Хөрсний шинж чанараас шалтгаалан замын суурийг оновчтой сонгох
- Гадаргуугийн ус зайлцуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлцуулах байгууламжийг цогцоор нь шийдэх. Геодези Усны Барилга Байгууламж ОНӨААТҮГ-тай зураг төслийг зөвшилцэх
- Инженерийн шугам сүлжээний байгууллагуудын техникийн нөхцөлийг тусгах, ажлын зураг боловсруулах, холбогдох байгууллагатай зөвшилцэх, ажлын зургийг батлуулах
- Авто замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, унадаг дугуйн зам, нийтийн тээвэр болон автомашины зогсоол, автомашин, явган хүний гарц, ногоон байгууламж, гадаргуугийн усыг зайлцуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх
- Авто замын төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах
- Авто замын трассад орсон барилга байгууламж, нийтийн эзэмшлийн эд зүйлсийг нарийвчлан гаргаж тайлбар бичигт газар чөлөөлөлтийн талаар тусгайлан оруулах, зургийн шийдлийн дагуу зайлцуулах бол тусгах
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх
- Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх. Замын Хөдөлгөөний Удирдлагын төвтэй зөвшилцэх
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах
- Явган хүний замыг явган зорчигч болон дугуйтай зорчигчид зориулан төлөвлөх
- Хучлагын гадаргуу нь явган зорчигчийн аюулгүй байдлыг хангасан, бат бэх тогтвортой, хальтиргаа, гулгаанаас хамгаалсан байна
- Байр зүйн болон өндрийн хэмжилтийг UTM системд хийх
- Авто замын гэрэлтүүлгийг төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК руу бие даан хандаж /өргөдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг тодруулах/ ажлын зургийг боловсруулах. Одоо байгаа гэрэлтүүлгийн шонг шилжүүлэх, дэд станцыг шилжүүлэх зэрэг холбогдох асуудлуудыг мөн шийдвэрлэсэн байх
- Авто замын гэрэлтүүлгийг эрчим хүчний хэмнэлттэй, шар тусгалтай чанарын шаардлага хангасан “LED” технологиор шийдвэрлэх
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:  
Дэвсгэр зураг

|  |               |
|--|---------------|
| Дагуу огтлол   | хэвтээ 1:1000 |
| босоо  | 1:100         |
| Хөндлөн огтлол   | 1:100         |
| Уулзвар, огтлолцол   | 1:500         |
| Бүтэц  | 1:20          |
| ➤ Нийслэлийн Хот байгуулалт, Хөгжлийн газрын Авто зам, замын байгууламж төлөвлөх архитектур төлөвлөлтийн даалгавар, НАЗХГ-ын Авто замын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын дагуу зураг төслийг боловсруулах   |               |
| ➤ Авто зам төлөвлөлтийн шатанд буюу авто замын план зургийг Нийслэлийн Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Нийслэлийн Газар Зохион Байгуулалтын Алба, Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ, ЗХУТ-тэй тус тус зөвшилцөний үндсэн дээр нарийвчилсан зураг төсөлд холбогдох газруудаас санал аван зураг төслийг баталгаажуулах.              |               |
| ➤ Тухайн замын үндсэн элементүүдийг (авто зам, гүүр, хоолой, зогсоол, хөдөлгөөн зохион байгуулалтын тэмдэг тэмдэглэгээ, инженерийн шугам сүлжээ, ус зайлзуулах байгууламж гэх мэт) Leyer тус бүрээр нь салгаж Autocad файлаар өгөх.  |               |
| ➤ Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө. |               |

Хянасан:

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн  
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

/О.Энхбаатар/

Боловсруулсан:

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн  
авто замын мэргэжилтэн

/Н.Энхтуяа/

2020 оны 02 сарын 03-ны өдөр

НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗАР

Газрын байршил  
Налайх дүүрэг, 1, 7-р хороо

Газрын зориулалт  
Авто зам, замын байгууламж



Таних тэмдэг

Төлөвлөж буй авто зам, замын байгууламж

Хянасан:  
НАЭХГ-ын Бодлого Зохицуулалтын хэлтсийн  
даргын албан ёуртийг түр орлон гүйцэтгэг /О.Энхбаатар/

Боловсруулсан:  
НАЭХГ-ын БЭХ-ийн авто замын мэргэжилтэн  
Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний авто зам /Н.Энхтуяа/

Хянасан:  
НАЭХГ-ын Бодлого Зохицуулалтын хэлтсийн  
даргын албан ёуртийг түр орлон гүйцэтгэг /О.Энхбаатар/

Боловсруулсан:  
НАЭХГ-ын БЭХ-ийн авто замын мэргэжилтэн  
Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний авто зам /Н.Энхтуяа/